

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№ 17/457

ШУС, НУС

2016

**СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНОЛЫН ФИЛОСОФИЙН АСУУДЛУУД СУДАЛГААНЫ**  
**БИЕ ДААСАН СУДЛАГДАХУУН БОЛОХ НЬ**

М.Зулькафиль\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

**Түлхүүр үг:** философи-социологийн арга зүй, категорийн систем, олон нийтийн мэдээлэл, мөн чанар ба үзэгдэл, гносеологийн үзэгдэл, оюуны үйлдвэрлэл, дунд түвшний онол

**О**рчин үед сэтгүүл зүйн онолын асуудлыг судалдаг, боловсруулдаг эрдэмтэн судлаачид “сэтгүүл зүйн шинжлэх ухааны цаашдын хөгжил юуны өмнө түүний онолын үндсийг боловсронгуй болгох, оршиж буй зүй тогтлуудыг нухацтай судлахаас шалтгаална... Сэтгүүл зүйн түүх, арга зүй, ОНМХ-ийн онцлогийг судлах, эсвэл сэтгүүл зүйн социологи зэрэг аль ч салбарт цаашдын танин мэдэх алхам сэтгүүл зүйн талаар хуримтлагдсан мэдлэгийг системчлэх, тэднийг нэгдмэл нэг зүйл болгон нэгтгэж буй дотоод харилцаа холбоог оновчтой тогтоохоос тодорхой хэмжээгээр шалтгаалах болно. Энэ зорилтын цөм нь цаашид сэтгүүл зүйн онолын категорийн системийг боловсруулах, өөрөөр хэлбэл сэтгүүл зүйн мөн чанарыг ойлгоход тусалдаг үндсэн

ойлголтуудын системийг боловсруулах явдал мөн”<sup>1</sup> гэдгийг онцлон тэмдэглэх болсон. Энэ бол сэтгүүл зүйн онолын тулгамдсан асуудлыг ойлгож эхэлж буйн шинж юм.

Судалгааны зарчим болон арга зүйн хүрээнд сэтгүүл зүйн тухай шинжлэх ухааны зорилт, бүтэц, судлагдахуун үзэл баримтлалын талаар ийм тодорхой ойлголтод хүрч эхэлсэн нь нааштай алхам юм. Энэ бол сэтгүүл зүйд шинжлэх ухааны хувьд бүхэлд нь хандах, дотоод харилцаа холбоо болон мэдлэгийн бусад “салбарууд”-ын харилцан уялдааны талаар ярих боломж олгодог арга зүйн чухал ач холбогдолтой сэтгүүл зүйн өвөрмөц метаонол юм.

Орчин үеийн нөхцөлд тийм метаонолын ач холбогдол онцгой чухал болж байна. Учир нь сэтгүүл зүйн шинжлэх ухааны өмнө шинэ, тэр дундаа прагматик чиглэлийн зорилтууд тулгарах болсон. Харин зарим судлаачийн сэтгүүл зүй шинжлэх ухааны хувьд одоохондоо бүрэн “цэгцэрч” чадаагүй, онолын цөөнгүй категори, ойлголт “эмх цэгцгүй” байгаа

гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Үнэн хэрэг дээрээ энэ шинжлэх ухаан сүүлийн хориод жилд боломжийн түвшинд хөгжсөн. Гэхдээ гол төлөв “өргөшөө” болон “гүнзгийрч” хөгжих хандлага давамгайлсан учраас сэтгүүл зүйн өөрийн онолын тулгамдсан асуудлуудыг боловсруулах ажил тодорхой хэмжээгээр орхигдоход нөлөөлсөн гэж хэлэх үндэстэй.

Үүний нэг сөрөг үр дагавар нь судалгааны категориуд нь хоорондоо зөрчилдөж, үндсэн ойлголтууд тогтвортой бус, нэр томъёоны хувьд маргаантай, судалгааны хүрээний үндсэн ойлголтуудыг ч нэг мөр хүлээн зөвшөөрөхөд хүндрэл учруулах болсон.

**К**атегорийн хувьд нэг мөр болоогүй байгаагийн нэг жишээг бол “сэтгүүл зүй үйл ажиллагаа” мөн болох ойлголт, нэр томъёо, илэрхийлэх арга, хандлагаас тод харж болно. Тухайлбал, “сэтгүүлчийн үйл ажиллагаа”, “сэтгүүл зүйн үйл ажиллагаа”, “сэтгүүлчийн уран бүтээлийн үйл ажиллагаа”, “ОНМХ-ийн үйл ажиллагаа”, “хэвлэлийн үйл ажиллагаа” гэх мэт категориыг зөвхөн ойролцоо утгатай нэр томъёо төдийгүй хоорондоо харилцан уялдаа холбоотой адилхан ойлголт гэж үздэг нь түгээмэл байна. Харин үнэн хэрэг дээрээ дээрх категори болгон өөрийн гэсэн онцлог, шинжийг агуулдаг тул ижил ойлголт гэж үзэх нь учир дутагдалтай юм. Энэ ойлголтууд ерөнхий агуулгаар нь ойролцоо утгатай боловч онолын хувьд ижил утгатай гэж үзэх нь зөвхөн логикийн хувьд төдийгүй бодит утга, агуулгын хувьд ч алдаатай юм. Ийм хандлагыг сэтгүүл зүйн онолын

бүтээлүүдээс харж болох бөгөөд энэ бол сэтгүүл зүйн категориын аппаратад хандах ажлыг дэндүү “хялбарчилж”, хэт өнгөцхөн авч үзэж буй хэрэг юм.

Жишээ болгон онолын үндсэн категори болох “сэтгүүл зүй” хэмээх ойлголтыг авч үзье. ОХУ-ын сэтгүүл зүйн нэрт онолч Е.П.Прохоров сэтгүүл зүйг дараах шинж, илрэлүүдийн нийлбэрийг агуулсан нийгмийн систем гэж тодорхойсон байдаг:

- сэтгүүл зүй бол нийгмийн өвөрмөц институт;

- сэтгүүл зүй бол үйл ажиллагааны төрлүүдийн систем;

- сэтгүүл зүй бол мэргэжлүүдийн нийлбэр;

- сэтгүүл зүй бол бүтээлүүдийн систем;

- олон нийтийн мэдээллийг дамжуулдаг сувгийн нийлбэр, эсвэл энэ бүхнийг нэгтгэж үзвэл нийгмийн өвөрмөц институт бөгөөд түүний хүрээнд үйл ажиллагаа нь янз бүрийн чиглэл бүхий олон нийтийн сувгуудад зориулсан бүтээл бэлтгэх мэргэжлийн өвөрмөц мэдлэг, чадварыг шаарддаг юм”<sup>2</sup>.

Тэгвэл сэтгүүл зүйн өөр нэг нөлөө бүхий судлаач С.Г.Корконосенко: “Сэтгүүл зүй бол нийгмийн чухал мэдээллийг цуглуулах, боловсруулах, тогтмол түгээх (тогтмол хэвлэл, радио, телевиз, кино г.м.) нийгмийн үйл ажиллагаа мөн; Үгийн өөр нэг утга бол редакци, телекомпани, мэдээллийн агентлаг, тэдний үйлдвэрлэл техникийн бааз зэрэг мэдээллийг цуглуулах, дамжуулах хэрэгсэл ба үйлдвэрүүдийн системийн илэрхийлдэг; мөн “сэтгүүл зүй” хэмээх нэр томъёогоор сонин, сэтгүүлийн дугаарыг, радио, телевизийн хөтөлбөрийг бүрдүүлж буй

сэтгүүлчийн үйл ажиллагааны бүтээлүүдийг нэрлэдэг”<sup>3</sup> гэж тодорхойлсон байдаг. “Сэтгүүл зүй” хэмээх ойлголтын тийм тайлбарыг бусад олон судлаач ч хүлээн зөвшөөрдөг.

Сэтгүүл зүйг ийм маягаар онолын ойлголт биш зөвхөн үзэгдэл гэж тайлбарлах нь судлагдахууны системийг бүрдүүлэгч үндсэн шинжүүдийг тодруулж чадахгүй байна. Энэ бол сэтгүүл зүй хэмээх өвөрмөц ойлголтын мөн чанарыг бүрэн илрүүлж чадахгүй гэсэн үг юм. Үнэн хэрэг дээрээ энэ ойлголтын хамгийн гол зүйлийг илрүүлэгч тал нь тодорхой бус байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл нийгмийн институт мөн үү? Эсвэл үйл ажиллагааны төрлийн систем үү? Эсвэл мэргэжлүүдийн нийлбэр үү? Судлаачийн тодорхойлолтод үүнийг “таслал”-аар ялгаж өгсөн бөгөөд эцсийн дүнд сэтгүүл зүйн “нийгмийн институт” гэсэн шинжид гол анхаарлаа хандуулж, бусад аспектүүдийг түүгээр дамжуулан тодорхойлохыг зорилго богосон байдаг.

Сэтгүүл зүй бол хүмүүсийн бүтээсэн нийгмийн институтын тусгай тохиолдлыг илэрхийлдэг бөгөөд тэдний хүсэл зоригоос гадуур бүрэлдэн тогтож чадахгүй. Гэхдээ үйл ажиллагаа нь “мэргэжлийн онцгой мэдлэгийг шаарддаг энэхүү өвөрмөц институт”-ыг хэн ямар зорилгоор бий болгосон нь тодорой бус үлддэг. Учир нь энэ тохиолдолд нийгмийн институт болох сэтгүүл зүйн хувьд энэхүү “хэн нэгэн” нь “анхдагч” болох ёстой бөгөөд түүгээр дамжуулан түүний бусад аспектүүдийг тодорхойлох боломжтой юм.

Онол (онол болж чадахын тулд) категорийн ойлголтын хувьд хоорондоо

харилцан уялдаа холбоонд оршдог категориудын системд анхдагч категориос салаалан тарсан байх ёстой. Зөвхөн ийм тохиолдолд л систем болж чаддаг, харин бүгд нэр томъёоны утгыг илэрхийлдэг гэсэн үндэслэлээр (энэ тохиолдолд “сэтгүүл зүй”) нэг дээвэр дор нэгтгэсэн категориудын цуглуулга биш юм.

Е.П.Прохоровын зарим бүтээлд “нийгмийн үйл ажиллагааны онцгой салбар болох сэтгүүл зүйн мөн чанар нь түүний олон нийтийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, эвлүүлэх, түгээх үйл ажиллагааны шинж чанараар” дамжин илэрдэг гэсэн дүгнэлт хийж, сэтгүүл зүйн онолын хамгийн гол, суурь ойлголт нь “олон нийтийн мэдээлэл”<sup>4</sup> мөн гэж тодорхойлолт бий. Мөн манай судлаачид ч ийм санал бодолтой байдаг нь ажиглагддаг. Бидний бодлоор энэ бол ямар ч маргаангүй дүгнэлт юм. Учир нь онолдахь *олон нийтийн мэдээллийн үйл ажиллагаа* гэж нэрлэдэг зүйл нь сэтгүүл зүйн *үзэгдэл* мөн. Өөрөөр хэлбэл түүний мөн чанар нь илэрдэг тэр зүйл мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Гэхдээ судалгааны аль ч бүтээлд сэтгүүл зүйн мөн чанарыг түүгээр дамжуулан бүрэн илэрхийлж чадаагүй бөгөөд зарим тохиолдолд хоорондоо логик зөрчилд орох нь түгээмэл юм.

**М**өн чанар бол илэрдэг, бий болдог, тэгвэл аливаа үзэгдэл мөн чанарын илрэл байдаг. Гэхдээ үүнээс мөн чанар, үзэгдэл хоёр нэг зүйл гэсэн дүгнэлт хийж болохгүй.

Тиймээс мөн чанарыг бус, мөн чанарын үзэгдлийг илэрхийлдэг

категори бол онолын категориудын системийн үндэс болж чадахгүй. Хэрэв энэ утгаар авч үзвэл олон нийтийн мэдээллийн үйл ажиллагаа нь сэтгүүл зүйн үзэгдэл болох учраас сэтгүүл зүйн онолын категорийн системийн үндэс, бүр тодруулж хэлбэл түүний хамгийн гол суурь категори болж чадахгүй гэж үзэх үндэстэй юм. Категорийн тийм систем нь онолын хувьд байх ёстой бодит байдлыг яг байгаагаар нь илэрхийлж чадахгүй.

Энэ нь тухайн категорийн систем болон суурь ойлголтын талаарх үндэслэл учир дутагдалтай байгаатай холбоотой. Бусад судлаачдын зарим тодорхойлолтыг ч ийм үндэслэлээр эсэргүүцэх, бас дэмжих боломжтой.

Харин сэтгүүл зүйн онолын анхдагч категорийн хувьд “оюуны үйлдвэрлэл”<sup>5</sup> хэмээх категорийг санал болгосон Германы судлаач Г.Першкегийн дүгнэлт энэ чиглэлд нааштай алхам хийсэн гэж хэлж болно. Судлаач сэтгүүл зүйн онолын категориудын системийг энэ онолын судлагдахууны мөн чанарыг оюуны үйлдвэрлэлийн төрөл мөн гэсэн ойлголтыг баримтлан анхдагч категорийг дэлгэрүүлэх үйл явц болох онолын категориудын системийг боловсруулах тал дээр томоохон амжилтанд хүрчээ.

Түүний сэтгүүл зүйн бүх системийг “үйлдвэрлэл-хуваарилалт-солилцоо-

хэрэглээ” гэсэн хоорондоо харилцан шилжиж байдаг үе шатуудаас бүрддэг давтамжтай үйлдвэрлэлийн бүтэц хэмээх ойлголтод тулгуурлан тайлбарлах гэсэн оролдлого нь үнэ цэнтэй бөгөөд харгалзан үзүүштэй дүгнэлт юм. Гэхдээ энэ хандлага хэдийгээр метаонолын хувьд ч, арга зүйн хувьд ч ач холбогдолтой боловч сэтгүүл зүйн онолын үндсийг бүрдүүлдэг гэж үзэх боломжгүй. Учир

нь онолын судлагдахуунд ийм маягаар хандахдаа сэтгүүл зүйн бидний эрж хайж буй мөн чанар нь бас илрэхгүй үлдэж, энэ үзэл баримтлалд мөн чанарыг түүнээс өөр эрс ялгаатай онцгой зүйл гэж ойлгох болно.

Оюуны үйлдвэрлэл бол сэтгүүл зүйд ямар ч эргэлзээгүй шууд хамаа-

тай бөгөөд түүний хамгийн чухал шинжийг илэрхийлдэг. Гэхдээ сэтгүүл зүй бол оюуны үйлдвэрлэл болох тухай ярихдаа өөрийн эхгүй түүний мөн чанар биш агуулгын тухай хөндөх шаардлага тулгардаг.

Харин Е.П.Прохоровын нэлээд олон жилийн өмнө хэвлэгдсэн өөр нэг бүтээлд сэтгүүл зүй хэмээх ойлголтыг нийгмийн амьдралыг олон нийтийн мэдээллээр хангах тусгай үүргүүдийн системийг биелүүлдэг нийгмийн үзэгдэл<sup>6</sup> гэж тодорхойлсон нь анхаарал татдаг. Энэ тодорхойлолтод зохиогч

«

***Онол (онол болж чадахын тулд) категорийн ойлголтын хувьд хоорондоо харилцан уялдаа холбоонд оршдог категориудын системд анхдагч категориос салаалан тарсан байх ёстой. Зөвхөн ийм тохиолдолд л систем болж чаддаг, харин бүгд нэр томьёоны утгыг илэрхийлдэг гэсэн үндэслэлээр нэг дээвэр дор нэгтгэсэн категориудын цуглуулга биш юм.***

»

хэдийгээр тодорхой нэрлээгүй ч гол анхаарлаа ямар нэгэн өвөрмөц үүргүүдийг биелүүлдэг гэсэн санаанд төвлөрүүлсэн нь сэтгүүл зүйн үйл ажиллагааны мөн чанарыг тодорхойлох, судлах чиглэлд ирээдүйтэй хандлага болох нь дамжиггүй юм.

Энэ мэтийн сэтгүүл зүйн онол дахь категори болон нэр томъёоны хувьд нэг мөр болоогүй, зөрчилтэй, маргаантай зүйл цөөнгүй байгаа нь онолын өнөөгийн байдлын, түүний хөгжил “өргөөшөө” явж, “эмх цэгцгүй” байгаагийн жам ёсны үр дагавар юм.

**Н**эг талаар, энэхүү “эмх цэгцгүй” байдал нь сэтгүүл зүйн тухай шинжлэх ухааны дутагдал биш, харин түүний дараа хуримтлагдсан мэдлэгийг системчлэх, категориудыг эмхлэн цэгцэлж, нэг мөр болгох оролдлого хийх шаардлагатай гэдгийг ухааран ойлгох зайлшгүй шаардлагатай үе мөн. Гэхдээ нөгөө талаар, энэ онолд дээр дурдсанчлан үндсэн ойлголтуудад энгийн, ёс төдий логикийн зөрчил хүртэлх логик-арга зүйн өөсэв оршиж байгаа нь зөвхөн сэтгүүл зүйн онолын төлөвшилтэй холбоотой түүхэн объектив шалтгааны үр дүн биш гэдэг асуудалд анхаарал хандуулахгүй байхын аргагүй юм. Эрдэмтэн судлаачдын аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрч байгаа сэтгүүл зүйн онолын “эмх цэгцгүй” байдал нь ОНМХ-ийн судалгааг олон жил эрхлэн явуулж буй судлаач бидний арга зүйн мэдлэг чадвар хангалттай түвшинд хараахан хүрээгүй байгаагийн илрэл гэж хэлж болно.

Бидний дэр дурдсан хэдэн жишээ зөвхөн сэтгүүл зүйн онол төдийгүй ОНМХ-ийн түүх, практик, арга зүйн судалгаанд ч нийтлэг бөгөөд нэг мөр

болоогүй, цаашид эмхэлж цэгцлэх зүйл дэндүү их байгааг хэлэх хэрэгтэй. Энэ бүхэн нь мэдээж судлаач биднээс метаололын судалгааг нухацтай хийхийг шаардаж буй хэрэг мөн.

“Сэтгүүл зүйн тухай шинжлэх ухаанд бүхэлд нь хальт харах боломж олгодог, бас үүнийг шаардаж буй, арга зүйн томоохон ач холбогдолтой сэтгүүл зүйн суурь метаолол”<sup>7</sup> бол бидний бодлоор сэтгүүл зүйн шинжлэх ухааны салбар бол сэтгүүл зүйн онолын философийн асуудлууд байх бөгөөд түүний эрх хэмжээний хүрээнд юуны өмнө онолын философи-арга зүйн дүн шинжилгээг хэрэгжүүлэх асуудал багтдаг.

Аливаа судалгааны статус болон агуулгыг ямар нэгэн онолын философи-арга зүйн дүн шинжилгээний үүднээс тодорхойлох явцад бид судалгааны “шинжлэх ухааны философи” эсвэл “шинжлэх ухааны философийн асуудлууд” гэж нэрлэгддэг тэр салбар руу ордог.

Гносеологийн (мэдлэгийн онол) үзэгдэл болох шинжлэх ухааны философийн асуудал гэж юу вэ? Энэ холбоо үгэнд ямар нэгэн агуулга орших уу, эсвэл “хоосон” ойлголтын бас нэг жишээ мөн үү? Гэхдээ энэ бол зүгээр нэг тохиолдлын, сэтгэл хөдлөлөөс гарч ирсэн асуудал огт биш юм. Учир нь энэ асуудлыг хөндсөн судалгааны бүтээл хэдийгээр хангалттай боловч өнөөдөр хүртэл “Байгалийн шинжлэх ухааны философийн асуудлууд хэмээх ойлголтыг ямар агуулгатай холбон тайлбарлах нь тодорхой бус байна” зэрэг асуулт цөөнгүй тааралддаг. Хэрэв энэ асуудал байгалийн шинжлэх ухааных бол яагаад философийнх болох вэ? Хэрэв үнэхээр философийнх бол

яагаад байгалийн шинжлэх ухааных болох вэ?<sup>8</sup>

Тэр тусмаа энэ ойлголт ихээхэн учир утгатай бөгөөд шинжлэх ухааны танин мэдэх үйл явцад тогтмол илэрдэг гносеологийн бодит байдлыг тусгадаг. Шинжлэх ухаанд тийм нөхцөл байдлыг нэлээд дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. Энэхүү тайлбарын товч утгыг дараах байдлаар илэрхийлж болно.

Шинжлэх ухаанд хандах философийн хандлагад хамгийн гол, тодорхойлогч зүйл бол судалгааны явцад олж авсан мэдлэгийг шинэчлэн баяжуулах, шинжлэх ухааны аливаа үзэгдлийг объектив бодит байдлыг танин мэдэх субъектийн үйл ажиллагааны үр дүн мөн гэдгийг батлахыг ойлгох явдал байдаг. Тиймээс шинжлэх ухааны философийн асуудлууд бол шинэчлэн баяжуулах, шинжлэх ухааны байгаа үр дүнг онолын үүднээс дахин сэргээх зорилтуудыг тодорхойлох, шийдвэрлэх явцад зайлшгүй тулгардаг философийн сонгодог асуудлууд мөн. Энэ бол танин мэдэхүйн хөгжлийн тодорхой үе шатууд дахь философийн агуулга тусгай шинжлэх ухааны агуулга болно гэсэн үг.

Гэхдээ философийн, шинжлэх ухааны тодорхой асуудлууд болон судалгааны аргууд нэгдмэл холбоонд оршдог шинжлэх ухааны философийн тулгамдсан асуудал болох гносеологийн объектүүд илэрдэг шинжлэх ухааны хөгжлийн энэхүү үе шатууд ямар байх бэ?

Энэ салбарын судлаачид шинжлэх ухааны философийн асуудал бол юуны өмнө философийн ойлголт, категори, зарчим болон хуулиудад агуулагддаг

ертөнцийг танин мэдэх, түүнийг эзэмших аргуудын тухай нийтлэг төсөөлөл ба шинжлэх ухааны танин мэдэх тодорхой үр дүнгийн талаарх зөрчлийн улмаас үүсдгийг тогтоосон байдаг.

Ингэхдээ шинжлэх ухааны философийн асуудлыг бий болгодог зөрчил өөрөө янз бүрийн шалтгаан үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Нэгдүгээрт, энэ бол шинжлэх ухааны тодорхой мэдлэгийн амжилт мөн. Энэ тохиолдолд асуудлын гол нь энэ үр дүнг соёлын системд бүхэлд нь “оруулах” замаар философийн үүднээс үндэслэх шаардлага байгаад оршино.

**Х**оёрдугаарт, энэ бол шинжлэх ухааны танин мэдэхийн сул тал юм. Энэ тохиолодолд философийн дүн шинжилгээ хийх шаардлага тухайн мөчид байгаль ба нийгмийн аливаа үзэгдлийг тайлбарлах шинжлэх ухааны арга хэрэгсэл байхгүй байгаад оршино. Ийм нөхцөлд философи бодит байдалд тохирсон шинжлэх ухааны танин мэдэх боломжийг бүрдүүлэх төдийгүй шинжлэх ухааны байгаа баримт, мэдээлэл болон философийн төсөөлөлд тулгуурлан тайлбар хийх хувилбарыг санал болгох учиртай. Тийм нөхцөл нэлээд сайн хөгжсөн онолын хувьд, мөн өөрийнхөө төлөвшлийн аль нэг шатанд байгаа онолд нийтлэг ажиглагддаг.

Шинжлэх ухааны философийн асуудал үзэгдэл болохын хувьд соёлын түүхэн тодорхой дэвсгэрт нэг ёсны “цалгиа” мэт илэрдэг бол шинжлэх ухааны танин мэдэх үйл явцын үр дүнд (ололт амжилт, алдаа дутагдлын хамт) үүссэн тийм үзэгдэл асуудлуудын

системийн нэгдлийг бүрдүүлдэг. Энэ бол:

а) философийн аливаа категорийн агуулгыг хөнддөг цэвэр философийн шинжтэй асуудлууд;

б) шинжлэх ухааны мэдлэг, үндсэн категорийн ойлголтын аппаратын бүтцийн логик дүн шинжилгээтэй хобоотой мета шинжлэх ухааны шинжтэй асуудлууд;

в) бодит байдалд тохирсон шинжлэх ухааны тодорхой онолын загварыг бүтээхтэй холбоотой цэвэр шинжлэх ухааны асуудлууд.

Онолын философийн асуудлын бүтцийн нэгдэл нь:

Нэгдүгээрт, асуудлын философийн хэсэг нь өөрөө шинжлэх ухааны тухайн салбарт тулгарч байгаа шинжлэх ухааны тодорхой асуудлуудын мөн чанарт гүнзгий нэвтрэхгүйгээр зөв томъёологдохгүй гэдэгт,

Хоёрдугаарт, шинжлэх ухааны философийн асуудлыг шийдвэрлэх явдал шинжлэх ухааны тодорхой асуудлуудыг шийдвэрлэсэн байдаас шалтгаалан түүнийг урьдчилж тодорхойлох боломж олгодог.

Гуравдугаарт, философийн нэгдсэн асуудлын хүрээнд шинжлэх ухааны тодорхой асуудлууд философийн хэсгийг томъёолох асуудалтай салшгүй харилцаа холбоонд бий болдог оршино.

Судалгааны шинж чанарын философи-арга зүйн дүн шинжилгээ болох онцлогийг тодорхойлох явцад “арга зүй” хэмээх ойлголтын зайлшгүй хөндөх шаардлага тулгардаг.

Философи бол шинжлэх ухааныг танин мэдэх ерөнхий арга зүй гэдэг дүгнэлтийг өнөөдөр хүн болгон мэднэ.

Ингэхдээ дараах зүйлийг анхааралдаа авах шаардлагатай. Энэ бол:

Нэгдүгээрт, арга зүй бол философи ба шинжлэх ухаантай зэрэгцэн оршдог оюуны ямар нэгэн онцгой үзэгдэл биш, арга зүй бол функци, түүний дотор философийн функци мөн. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны танин мэдэх системд гүйцэтгэдэг үүргийн талаас нь сонгон авсан философи өөрөө тухайн тохиолдолд түүнийг танин мэдэх хэрэгсэл болно гэсэн үг юм.

Хоёрдугаарт, энэ үүргийг философи мөн гэсэн утгаар нь хүлээн зөвшөөрөхдөө философийн систем болгон үүнийг биелүүлэх боломжгүй гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй. Зөвхөн шинжлэх ухааны философи л шинжлэх ухааны танин мэдэх хэрэгсэл болж чадна. Өөрөөр хэлбэл өөрийнхөө дүгнэлтийг шинжлэх ухаанд ойр оюун дүгнэлтийн зарчмуудын үндсэн дээр хийж, мэдлэгийг онолын хэлбэрт оруулж, дүгнэлтээ логикийн үүднээс нотлоход тэмүүлдэг. Үүгээр шинжлэх ухааны философи философийн бусад төрлүүдээс ялгаатай юм.

**Д**ээр дурдсан зүйлүүдээс сэтгүүл зүйн салбарын онолын судалгаанд харгалзан үзэх боломжтой ямар арга зүйн дүгнэлтийг хийж болох вэ? Тэднийг дараах байдлаар илэрхийлж болно. Үүнд:

1. Орчин үед сэтгүүл зүйн онол хүний үйл ажиллагааны төрлийн онолыг боловсруулах болон төлөвших шатандаа байна. Түүний объект болох сэтгүүл зүй хөгжлийн хувьд сонгодог, боловсронгуй хэлбэрт хүрч, түүний үндсэн дээр тохирсон онолыг боловсруулах боломж бүрдсэн.

2. Хэдийгээр ийм боловч тодорхой шалтгаануудын, түүний дотор субъектив шинжтэй шалтгаантай холбоотой сэтгүүл зүйн онол өнөөдөр энэ төрлийн онолд тавигдах шаардлагын хэмжээнд судлагдахуунаа онолын хувьд жинхэнэ утгаар илэрхийлэх чадваргүй байна.

3. Сэтгүүл зүйн онол өөрийнхөө үндсэн ойлголтуудыг жинхэнэ утгаараа боловсруулах чадваргүй байгаа гол шалтгаанууд нь:

- онол хэт үзэл сурталжиж, үзэл суртлын янз бүрийн номлолоор бохирдсон нь үйл ажиллагааны мөн чанарыг илрүүлэх тэр чадварт нь сөрөг нөлөө үзүүлсэн;

- онолын үндсэн ойлголтуудыг боловсруулдаг судлаачдын арга зүйн түвшин хангалтгүй байсантай холбоотой юм.

Дээрх шалтгаанууд харилцан нөхцөлдсөн уялдаа холбоотой байсан нь тэдний сөрөг нөлөөллийг улам хүчтэй болгосон байдаг.

4. Дээр дурдсан шалтгаанууд нь сэтгүүл зүйн онолд арга зүйн хувьд хангалттай шалгагдаагүй парадигмуудад үндэслэснээс болж тухайн үед шинжлэх ухааны хувьд өөрийнхөө судлагдахууныг тайлбарлах шинжлэх ухааны арга хэрэгслээ олж чадахгүй байдал үүссэн. Нэг талаар, онолын объект (сэтгүүл зүй өөрөө үйл ажиллагааны систем мөн) ба түүний онол дахь тусгалын (орчин үеийн нөхцөл дэх сэтгүүл зүйн онол) хооронд, нөгөө талаар, сэтгүүл зүйн онолын үр дүн ба нийгмийн тухай философийн, ерөнхий социологийн төсөөлөл болон нийгмийн шинжлэх ухаанд байдаг түүнийг танин мэдэх аргуудын хооронд зөрчил үүссэн байдаг.

5. Сэтгүүл зүйн онолын тийм философийн арга зүйн дүн шинжилгээний зорилго бол энэ онолын судлагдахууны тайлбарыг боловсруулах явдал юм. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны систем болох сэтгүүл зүйн категори ба ойлголтуудын системийн бодит байдалд илэрхийлэгдсэн, шинжлэх ухааны шаардлагад нийцэхүйц үндсэн зүй тогтлуудыг боловсруулах шаардлагатай гэсэн үг.

6. Энэ зорилтыг шийдвэрлэх чухал урьдач нөхцөл бол мэдлэгийн энэ салбарын судалгааны үр дүнг философийн үүднээс эзэмшихэд чиглэгдсэн философи-социологийн хандлага, энэ мэдлэгийг тухайн (өөрөөр хэлбэл шинжлэх ухааны) философийн ерөнхий зарчмуудын үндсэн дээр шинэчлэн баяжуулах оролдлого, түүний дотор тэдэнтэй ажиллах дүрэм журам (логик) болох ёстой юм.

7. Бидний дээр дурдсан бүх зүйл бол сэтгүүл зүйн онолын үр дүнг шинэчлэн баяжуулах, сэргээн боловсруулах зорилтыг тавих, шийдвэрлэх шаардлагын үүднээс үүссэн философийн асуудлууд гаднаас хүчээр оруулсан зүйл биш, харин энэ онолын өөрийн агуулга юм.

**Ү**үнтэй холбоотой зарим судлаачийн сэтгүүл зүй бол цэвэр хавсарга шинжлэх ухаан гэсэн үзэл бодлыг хуваалцах боломжгүй юм. Тухалбал: “Эцсийн эцэст бид туршилт руу хэчнээн тэмүүлж, философийн өндөрлөгт хүрэхийн тулд хэчнээн хөдөлмөрлөсөн боловч манай шинжлэх ухаан хавсарга шинжлэх ухаан (социологид дунд түвшний онол гэж нэрлэдэг тэр зүйл) хэвээрээ үлдэх болно. Харин бид



шинжлэх ухааны бүтцэд чанарын хувьд биш, эзлэх байрны хувьд энэ чигээрээ үлдэхийн тулд анхаарлаа хандуулах хэрэгтэй”<sup>9</sup> гэсэн дүгнэлтийг хэлж болно.

Сэтгүүл зүйн онол социологийн мэдлэгийн систем дэх статусын хувьд үнэхээр дунд түвшний социологийн онол мөн юм.

Гэхдээ сэтгүүл зүйн тухай шинжлэх ухаан мэдлэгийн систем болохын хувьд агуулгын талаасаа олон түвшинт бүтэцтэй юм. Энэ бол өөрийнхөө давхруудыг практикаас босгодог “олон давхар” шинжлэх ухаан гэсэн үг. Өөрөөр хэлбэл өөрчлөн шинэчлэх үйл ажиллагаанаас хийсвэрлэн сэтгэх шатаар дээшилсээр философийн ерөнхийлсөн дүгнэлт хүртэл хүрдэг онцлогтой. Дараах зүйл түүний элемент, давхрыг бүрдүүлдэг.

**С**үүлийн жилүүдэд практикт сэтгүүл зүйн социологийн тодорхой туршилтын төрөл болгон инженерийн судалгаа, нийгмийн инженерчлэлийг ашиглах болсон. Энэ нь шинжлэх ухаан практикт харьцангуй өндөр түвшний онолд суурь материал болж чадахуйц туршилтын анхдагч нэгтгэсэн дүгнэлтүүдийг өгч байна. Гэхдээ “харьцангуй өндөр түвшин” гэсэн нэр томъёо ямар ч үнэлэлт өгөх зорилго агуулахгүй, зөвхөн тодорхой объекттай холбоотой шүүмжлэлээс эргэцүүлэн бодоход шилжих боломж олгохын тулд арай өргөн хүрээний хийсвэрлэлийн тухай яригдаж байгаа хэрэг юм.

Дараагийн шат (давхар) бол “ер нь хүлээн авагч”, “байгаа хүлээн авагч” гэсэн ойлголтыг иш үндэс болгодог дунд түвшний онол болох сэтгүүл зүйн

өөрийн социологи юм. Хийсвэрлэлийн дараагийн арай өндөр шатанд гарах замаар бид “сэтгүүл зүйн үйл ажиллагааны объект” гэсэн ойлголтод хүрдэг. Энэ бол сэтгүүл зүйн шинжлэх ухааны түвшин бөгөөд түүнийг заримдаа “сэтгүүл зүйн ерөнхий онол” гэж нэрлэдэг. Эцэст сэтгүүл зүйн шинжлэх ухааны хүрээн дэх онолчирхохын дээд түвшин нь онолын социологи, бүр философи-социологийн онолтой холбогдох зааг дээр орших тэр муж юм. Энэ түвшин бол сэтгүүл зүйн онолын философи-социологийн тулгамдсан асуудлууд мөн.

Хийсвэрлэлийн шатаар тэгж авиран гарахын зорилго нь юунд орших вэ? Үүний гол зорилго нь шинжлэх ухааны арга хэрэгслээр аль хэдийд шалгагдсан практикт буцаж ирэх явдал бөгөөд түүний нэр нь арга зүйн нэгэн адил зохион байгуулагдсан “ойлголтын аппарат” юм.

Энд хавсарга социологийн судалгааг яаж явуулах вэ, түүнд юу хэрэгтэй вэ? гэсэн энгийн асуулт гарч болно.

Мэдээж материал-техникийн бааз, асуулгыг явуулах, хариултыг боловсруулах социологичдоос гадна зарим нэг онолд үндэслэгдсэн, анкетийн асуултуудыг боловсруулах, түүврийг тодорхойлох боломж олгодог судалгааны таамаглал онцгой чухал байдаг.

Судалгааны таамаглалыг томъёолох нь тодорхой судалгааны хамгийн чухал хэсгийн нэг юм. Тиймээс аливаа судалгааны ажил, түүний дотор социологийн судалгаа онолын хэсэг, судалгааны үндэслэлд зориулагдсан бүлгээс эхэлдэг. Хавсарга шинжлэх ухаанд тийм үндэслэлийг боловсруулах боломжгүй юм.

Нөгөө талаар социологийн тодорхой судалгаа зөвхөн шинжлэх ухаанд туршилтын материал өгөөд зогсохгүй. Энэ судалгааны дүгнэлт, үр дүн бол судалгааны объект болсон байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, улам боловсронгуй, оновчтой болгоход чухал ач холбогдолтой юм.

Тиймээс хавсарга, эсвэл онолын гэдгээс үл шалтгаалан шинжлэх ухааны үйл ажиллагааны ямар ч материал эцсийн дүнд практик үйл ажиллагааг боловсронгуй болгох, сайжруулахад чиглэгдсэн байдаг гэж итгэлтэй хэлж болно.

**Ш**инжлэх ухааны янз бүрийн давхар ба практикийн хоорондох холбоо янз бүр байдаг нь ойлгомжтой. Инженерийн социологийн судалганы хувьд энэ холбоо шууд, бусад давхрын хувьд дам шинжтэй байдаг. Хийсвэрлэлийн түвшин өндөр байх тусам дам холбооны гинж урт байдаг нь тодорхой.

Сэтгүүл зүйн тухай шинжлэх ухааны тодорхой хэсэг нь хавсарга гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ сэтгүүл зүйн тухай шинжлэх ухаан зөвхөн хавсарга шинжлэх ухаан гэж төсөөлөх нь учир дутагдалтай төдийгүй онолын үүднээс буруу хандлага юм.

Сэтгүүл зүйн шинжлэх ухааныг хавсарга шинжтэй гэсэн үзэл санааг баримтлагчдад практикт зөвхөн онолыг санал болгож болно, өөр ямар ч зүйл хэрэггүй гэдэг санаа агуулагдаж буйг ажиглах хэрэгтэй. Бодит байдлыг практик ба онол гэж хуваадаг тул бусад хувилбарт орон зай алга гэдэг нь тодорхой. Хэрэв хэн нэгэн бодит байдлыг практик ба өөр ямар нэгэн зүйлд хуваах юм бол тэр “ямар нэгэн

зүйл” нь зөвхөн онол байх болно гэдэгт эргэлзэх хэрэггүй. Үүнээс үзэхэд тэр эрж хайж буй “ямар нэгэн зүйл” бол онол бөгөөд түүнийг практикт нэвтрүүлэх боломжтой.

Дээр өгүүлсэн зүйлийг нэгтгэн дүгнэвэл шинжлэх ухааны судалгааны судлагдахуун болох сэтгүүл зүйн онолын философийн асуудлууд нь асуудлын логик талд нь түлхүү анхаарсан сэтгүүл зүйн онолын арга зүйн өвөрмөц “өөрийн дүн шинжилгээ”, өөрийн эргэцүүлсэн бодол юм. Өөрөөр хэлбэл энэ дүн шинжилгээ онолын категорийн ойлголтын бүтцэд чиглэгдсэн бөгөөд түүний дотоод элементүүд нь онолын өнөөгийн байдалд шүүмжлэлтэй хандах, энэхүү тулгамдсан цогц асуудлыг сэтгүүл зүйн онол дахь олж авсан, нийгмийн институт болох сэтгүүл зүйн үндсэн зүй тогтлуудын илэрхийлэл болж буй үр дүнг философи-социологийн үүднээс эзэмших замаар шийдвэрлэх хувилбаруудыг санал болгох явдал юм.

## Ишлэл

*Прохоров Е. П.* 1993. Предмет и структура науки о журналистике // Основные понятия теории журналистики. М., с.26 - 27.

<sup>2</sup> См.: *Прохоров Е. П.* 1995. Введение в теорию журналистики, М., с.12-13.

<sup>3</sup> *Корконосенко С. Г.* 1995. Основы теории журналистики. СПб., с.3.

<sup>4</sup> *Прохоров Е. П.* 1995. Введение в теорию журналистики. М., с. 30.

<sup>5</sup> См.: *Першке Г.* 1993. Журналистика как отрасль духовного производства // Основные понятия теории журналистики. М.

<sup>6</sup> *Прохоров Е. П.* 1993. Предмет и структура науки о журналистике // Основные понятия теории журналистики. М., с.35.

<sup>7</sup> Там же, с. 26-27.

<sup>8</sup> Акулов В. Л. 1986. Диалектический материализм как система. Минск, с. 156.

<sup>9</sup> Фомичева И. Д. 1993. Журналистика переходного периода: развитие практики и вызов науке // Основные понятия теории журналистики. М., с. 5.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Акулов В. Л. 1986. Диалектический материализм как система. Минск.

2. Корконосенко С. Г. 1995. Основы теории журналистики. С-Пб.

3. Першке Г. 1993. Журналистика как отрасль духовного производства // Основные понятия теории журналистики. М.

4. Прохоров Е. П. 1993. Предмет и структура науки о журналистике // Основные понятия теории журналистики. М.

5. Прохоров Е. П. 1995. Введение в теорию журналистики. М.

6. Фомичева И. Д. 1993. Журналистика переходного периода: развитие практики и вызов науке // Основные понятия теории журналистики. М.

#### **Резюме**

Статья посвящена одному из сложных и спорных среди исследователей вопросов современной журналистики – философским проблемам теории журналистики. Автор опираясь на некоторые спорные выводы и теоретические концепции о сущности и основных понятиях журналистики и старается раскрыть причины таких разногласий. Также автор предлагает вариант решения совокупности этих проблем на основе философско-методологического освоения результатов, полученных в теории журналистики, выступающей отражением основных закономерностей самой журналистики как общественного института и вида духовной деятельности.